



БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 10 сарын 10

№ 292

Улаанбаатар  
хот

Дүрэм, хөлс төлөлтийн  
сан байлах тухай

Мах-тос бэлтгэлийн Компаниас ирүүлсэн дүрмийн төсөл, хөлс төлөлтийн сангийн саналыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

2. Мах-тос бэлтгэлийн компанийн дүрмийг I хавсралтаар, сард тогтвортой мөрдөх сарын цалингийн санг 324,0 мянган төгрөгөөр /хавсралт II/ тус тус баталсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА

Л.ЭНЭБИИ

ХӨРӨГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН



1991 оны 9 сарын 10 ны өдрийн  
Улаанбаатар хотын АХ-ны гүйцэт-  
гэх захиргааны 292 дугаар  
тогтоолын I хавсралт

**УЛААНБААТАР ХОТЫН МАХ-ТОС БЭЛТГЭЛИЙН  
КОМПАНИ /УҮГ/-ИЙН ДҮРЭМ**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

I.1. Мах, тос бэлтгэлийн компани нь Улаанбаатар хотын хөдөл-  
мөрчдийн төвлөрсөн хэрэгцээнд улсын даалгавраар бэлтгэгдэх мах,  
махан бүтээгдэхүүн, цөцгийн тос, түүнчлэн идэшний тос, гүүний  
айраг, цагаан идээг мах боловсруулах үйлдвэр пүүс, хөдөө аж ахуйн  
болон хэрэглээний хоршооны байгууллагуудаас аж ахуйн гэрээний  
үндсэн дээр авч зорь агуулахад хадгалж нөөцлөх, өдөр тутам ху-  
ваарилж түгээх үндсэн үүрэгтэй улсын үйлдвэрийн газар /УҮГ/ мөн.

I.2. Мах, тос бэлтгэлийн компани Улаанбаатар хотын Ардын  
Хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд аж ахуйн тооцоон дээр ажил-  
лана.

I.3. Компани нь БНМАУ-ын хууль тогтоомж, хотын АХ-ын тэр-  
гүүлэгчид, гүйцэтгэх захиргааны тогтоол захирамж, бусад эрх зүйн  
актуудыг удирдлага болгоно.

I.4. Компанийн эд хөрөнгө нь үндсэн сан, эргэлтийн хөрөнгө,  
бусад санхүүгийн нөөцөөс бүрдэж БНМАУ-ын хууль тогтоомж, аж  
ахуйн нэгжид олгогдох эрхийн дагуу эзэмшин ашиглаж захиран зар-  
цуулах ба бие даасан тайлан тэнцэл гаргана.

I.5. Компани нь еерийгөө удирдах, төлөвлөх, хөгжүүлэх зарчим  
дээр ажиллахаас гадна хөдөлмөрчдийн амжиргааны төвшинтэй уялдаж  
мах, цөцгийн тос зэрэг бүтээгдэхүүн, холбогдох үйлчилгээний үнэ  
тариф чөлөөт үнийн тогтолцронд бүрэн шилжээгүй тохиолдолд улсын  
дотацтай ажиллана.

I.6. Компани нь нэр бүхий албан бичгийн болон тушаалын хэв-  
лэлийн дардас, тамга /тэмдэг/ банканд гадаад дотоодын тооцрон  
харилцах данстай байна.

I.7. Компани нь орон тоо зохион байгуулалт, бүтцээ оновчтой  
тогтоож дотооддоо баталж мөрдөхөөс гадна компанийг Улаанбаатар  
хотын АХ-ын гүйцэтгэх захиргаанаас томилогдсон захирал толгойлж  
хотын өмнө хүлээсэн үүрэг зорилтоо хэрэгжүүлж ажлаа хотын ардын  
хурлын өмнө тайлагнана.

2.

1.8.Компанийн захирал нь БНМАУ-ын хууль тогтоомжуудад тогтоогдсон эрх хэмжээнийхээ дотор тушаал, шийдвэр гаргаж, биелэлтийг зохион байгуулж ажиллана.

1.9.Компани нь захирлын зөвлөл байгуулж, дүрэмд заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон цаг үеийн тулгамдсан асуудлуудыг авч хэлэлцэж протокол гаргахаас гадна хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдөнө.

Компанийн захирал нь хотын АХ-ын гүйцэтгэх захиргаатай, мөн ажилтнуудтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

1.10.Компанийг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тогтоолоор еөрчлөх буюу татан буулгана.

ХОЁР.Компанийн эрх

2.1.Нийслэл хотын хүн амыг мах махан бүтээгдэхүүн,цөцгийн болон идэшний тос бусад хүнсний бүтээгдэхүүнээр хангадаг,худалдаж авдаг үйлдвэр, хоршоолол, ард иргэд, худалдаа хоолны болон хэрэглэгч байгууллагууд, ажил үйлчилгээний чиглэлээр харилцах байгууллагатай гэрээ байгуулах, хэлцэл хийх.

2.2.Зоорь агуулах,барилга байгууламжийг шинээр байгуулах, шинэтгэх, өргөтгөх, тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгө, эд хогшлыг худалдан авах, борлуулах,хасах,түрээслэн ашиглах,бусдад түрээслүүлэх.

2.3.Улсын стандарт техникийн нөхцөл,ариун цэвэр, эргүүл ахуйн болон үнэ гэрээний шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг хүлээн авах, худалдах, үнийг төлөхөөс татгалзах.

2.4.Компани нь гадаад худалдааны үйл ажиллагаа явуулах эрхтэй ажиллаж,бусад орны үйлдвэр,компани, пүүстэй харилцаа тогтоох, гэрээ, хэлэлцээр байгуулах, экспорт импортын үйл ажиллагаа явуулахад шаардагдах барааны нөөц /улсын даалгавраас гадуур/ бий болгох зарцуулах.

2.5.Хүнсний хангамжийн нөөц, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн өмчийн болон Хөдөө аж ахуйн байгууллага, ард иргэд, бусад зах зээлээс мал, махан бүтээгдэхүүн,тос болон бусад хүнсний бүтээгдэхүүн дагалдах бэлтгэлийн зүйлийг улсын даалгавраас гадуур олж бэлтгэн гадаад дотоод зах зээлд худалдах,жижиг үйлдвэрлэл явуулах.

3.

2.6. Ажил үйлчилгээний үр дүнгээр ажилчин албан хаагчдыг орлого, цалингийн сандаа багтаан сар, улирал, жилээр шагнаж урамшуулах асуудлыг дүрмээрээ зохицуулах.

Төргүүний хүмүүсийг шагнаж урамшуулах, төр засгийн шагналд тодорхойлох.

ГУРАВ. Компанийн үүрэг

3.1. Компани нь мах тосны хадгаламжийн аж ахуйг хөгжүүлэх, хөргүүлийн техник технологи, хуваарилалт, түгээлтийн дэвшилттэй арга - сүлжээ нэвтрүүлэх.

3.2. Нийслэлийн хүн амын мах, тосны эрэлт хэрэгцээ, нөөцийг тооцож, эх үүсвэрийг нэмэгдүүлэх санал, захиалга, хангамжийн зохистой бодлого боловсруулж шийдвэрлүүлэх.

3.3. Мах тосны хангамж зарцуулалтын талаар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хариуцах, хяналт тавих, нөөцийг бүрдүүлэх, сан үлдэгдлийг баталгаатай хариуцах.

3.4. Мах тосны хангамж үйлчилгээний талаар хот, дүүргийн худалдаа, хоолны компанитай үйл ажиллагаагаа нэгтгэж ажиллах, бүтээгдэхүүний үнэ, чанартай холбогдсон асуудлыг шуурхай авч үзэж хяналт тавих.

3.5. Улаанбаатар хотын Худалдаа хоолны болон бусад хэрэглэгч байгууллагад мах махан бүтээгдэхүүн, тосыг хүн амын тоо, байршил, хэрэгцээг харгалзан хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэрийг үндэслэн сар жилээр хуваарилж өдөр тутам жигд хангах.

3.6. Хамт олны нийгмийн бодлогын асуудлыг шийдвэрлэх нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.